

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Худалдах, худалдан авах гэрээ гэрээ (*цаашид* “Гэрээ” гэх)-г Нэг талаас “.....” ХХК (улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, цаашид “Худалдан авагч” гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал, Нөгөө талаас: “.....” ХХК (улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, цаашид “Худалдагч” гэх)-ийг төлөөлж захирал /цаашид хамтад нь талууд гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээгээр худалдагч тал худалдан авагчийн захиалгын дагуу Барилгын салбарт мөрдөгдөж буй Олон Улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, шаардлагыг бүрэн хангасан, Худалдан авагчийн хэрэгжүүлж буй барилгын төсөлд бүрэн тохирох хэрэглэгдэх..... (*цаашид бараа гэх*)-ийг энэхүү гэрээнд заасан нөхцөл журмын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөх, худалдан авагч тал гэрээгээр тохиролцон тогтоосон хугацаанд барааны үнийг төлөх, үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 2.1 Энэхүү гэрээгээр цаашид худалдагчаас худалдан авагчид нийлүүлэх материалын нэр төрөл, м³, хэмжээ, үнэ зэргийг талууд гэрээний Хавсралт-аар батална. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болно.
- 2.2 Худалдан авагч тал барааны нэмэлт захиалга хийх шаардлага гарвал худалдагчид энэ тухайгаа болон барааны нэр төрөл, м³, хэмжээ зэргийн захиалгыг 1 /нэг/ хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Худалдагч талын эрх үүрэг

- 3.1.1. Худалдагч тал худалдан авагч талын захиалсан барааны нэр төрөл, тоо м³, хэмжээний дагуу худалдан авагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.1.2. Худалдагч нь гэрээний шаардлагад нийцсэн барилгын материал буюу бараа түүнд холбогдох баримт бичгийг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 3.1.3. Барааг худалдан авагчид Актаар хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд гарч болох аливаа эрсдлийг Худалдагч тал бүрэн хариуцна.
- 3.1.4. Худалдаж байгаа барааны зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон бүрэн мэдээллийг Худалдан авагчид өгөх үүрэгтэй
- 3.1.5. Бараны тээвэрлэлтийн зардалыг бүрэн хариуцана.
- 3.1.6. Гэрээгээр тохиролцон тогтоосон хугацаанд барааны үнийг төлөхийг, барааг хүлээн авахыг худалдан авагч талаас тус тус шаардах эрхтэй.
- 3.1.7. Үүргээ гүйцэтгээгүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гэрээгээр тогтоосон хэмжээгээр анз төлөх үүрэгтэй.
- 3.1.8. Худалдагч тал барааг тасралтгүй нийлүүлж байх зорилгын үүднээс худалдан авагч талын барааны захиалгын мэдээг авах эрхтэй.

/Үргэлжлэл бий /